



ДУНДГОВЬ АЙМАГ
ДЭЛГЭРЦОГТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 03 өдөр

Дугаар

А/23

Амардалай

Ажлын хэсэг томилох тухай

Монгол улсын Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1, 7.2 дах заалт, 8 дугаар зүйлийн 8.2 дах заалт, агаарын бохирдлын төлбөрийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3, Авто замын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.3, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1, 10.1.7, 10.1.8, Засгийн газрын 2016 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 312 дугаар тогтоол, Монгол улсын Зам, тээврийн хөгжлийн сайд, сангийн сайдын 2023 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн хамтарсан А/5748 дугаар тушаал, Аймгийн Засаг даргын 2023 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн А/174 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тус суманд Автотээврийн хэрэгслийн шинэчилсэн бүртгэл, техникийн хяналтын улсын үзлэг тооллого явуулах, албан татвар, төлбөр, хураамжийн дагуу бүрдүүлж, сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй байгууллага, аж ахуй нэгж, иргэдийн эзэмшилд байгаа бүх төрлийн тээврийн хэрэгслийг шинэчилсэн тоо бүртгэлд оруулах ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг доорх бүрэлдэхүүнтэй томилсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Ч.Баярмаа (Төрийн сангийн мэргэжилтэн)

Нарийн бичгийн дарга: Д.Ганчимэг (Татварын улсын байцаагч)

Гишүүд: Б.Азжаргал (Хэсгийн төлөөлөгч)

Б.Довуучий (1 дүгээр багийн Засаг дарга)

Г.Сосорбурам (2 дугаар багийн Засаг дарга)

Б.Баатарсүрэн (3 дугаар багийн Засаг дарга)

Бү.Баярмаа (Засаг даргын Тамгын газрын ажилтан)

2. Комиссын гишүүд сум орон нутагт байгаа автомашин болон өөрөө явагч хэрэгслийн тооллого явуулахад шаардагдах бэлтгэл ажлыг хангаж, техникийн улсын үзлэг тооллогыг цаг хугацаанд нь явуулан, тайлан мэдээг холбогдох газарт тавьж шийдвэрлэхийн ажлын хэсгийн ахлагч (Ч.Баярмаа)-д даалгасугай.

ДАРГА

М.БАЯРСҮХ

487301887